



2019 оны 02 дугаар сарын 19  
№07/1060/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол**

**Төрийн албаны зөвлөлийн  
үйл ажиллагааны дүрэм  
батлах тухай**

**Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол**

**Монгол Улсын Их Хурлын  
2019 оны хаврын ээлжит  
чуулганаар хэлэлцэх  
асуудлын тухай**

**Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол**

**Монгол Улсын нутаг  
дэвсгэрт иргэн шилжин  
суурьших хөдөлгөөнийг  
бүртгэх, мэдээлэх журам  
батлах тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

51.	Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтэц батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай	Дугаар 07	206
52.	Төрийн албаны зөвлөлийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 12	207
53.	Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох тухай	Дугаар 13	207
54.	Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм батлах тухай	Дугаар 17	208
55.	Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай	Дугаар 18	218
56.	Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай	Дугаар 19	221
57.	Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам батлах тухай	Дугаар 20	224
58.	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай	Дугаар 21	232
59.	Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 24	238

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

60.	Журам батлах тухай	Дугаар 327	241
61.	Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам батлах тухай	Дугаар 332	250
62.	Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам батлах тухай	Дугаар 339	254



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 01 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар  
хот

### **Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтэц батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай**

Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 65 дугаар зүйлийн 65.3, 65.4, 65.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтцийг доор дурдсан газартай байхаар баталсугай:

- 1.1.Захиргаа, удирдлагын;
- 1.2.Сонгон шалгаруулалтын;
- 1.3.Хүний нөөцийн удирдлага, аудитын;
- 1.4.Маргаан хянан шалгах.

2.Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны орон тооны дээд хязгаарыг 56 албан хаагчтай байхаар тогтоосугай.

3.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжийг байгуулж ажиллуулахыг Төрийн албаны зөвлөлд зөвшөөрсүгэй.

4.Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ баталсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн ажиллах нөхцөл, үйл ажиллагаанд шаардагдах төсөв, санхүү хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

5.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны бүтэц, орон тоог батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 70 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 12

Улаанбаатар  
хот

### **Төрийн албаны зөвлөлийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Балтавын Цогоогийн Төрийн албаны зөвлөлийн даргын бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар  
хот

### **Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2, 68.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Должингийн Баатарсайхан, Дорждамбын Зүмбэрэллхам, Бадамцоогийн Идэрчулуун нарыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 17

Улаанбаатар  
хот

### Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм батлах тухай

Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 65 дугаар зүйлийн 65.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн дүрэм батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2009 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 87 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

Монгол Улсын Их Хурлын 2019 оны  
17 дугаар тогтоолын хавсралт

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

#### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмийн зорилго нь Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн Төрийн албаны зөвлөлийн зорилго, зорилт, чиг үүрэг, бүрэн эрх, бүтэц, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалт, арга, хэлбэрийг тодорхойлж, бусад байгууллагатай харилцах харилцааг зохицуулахад оршино.

1.2.Төрийн албаны зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ нь төрийн албаны төв байгууллага мөн.

1.3.Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, эдгээр хуультай нийцсэн холбогдох бусад хууль тогтоомж болон энэ дүрмийг баримтална.

1.4.Зөвлөл Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлахаас гадна шийдвэр гаргахдаа хамтын удирдлагын зарчмыг мөрдөж ажиллана.

1.5.Зөвлөл хараат бус, бие даасан байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.

1.6.Зөвлөлийн эрхэм зорилго нь төрийн албаны чадахуй /мерит/-н зарчмыг сахиулж, улс төрийн зүй бус нөлөөллөөс ангид, иргэдийн итгэл хүлээсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино.

1.7.Зөвлөлийн зорилт нь Төрийн албаны тухай хуульд заасан бүрэн эрх, чиг үүргийнхээ хүрээнд төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай, ёс зүйтэй байдлыг хангахад чиглэнэ.

1.8.Зөвлөл нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

### **Хоёр.Зөвлөлийн бүрэн эрх**

2.1.Зөвлөл Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна дараах эрх эдэлнэ:

2.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж томилох үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгөх;

2.1.2.төрийн алба, төрийн албан хаагчтай холбогдох шаардлагатай мэдээ, судалгаа, баримт бичиг, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн талаарх мэдээлэл, төрийн албан хаагчийг ажил, албан тушаалд эгүүлэн тогтоох, хохирлыг нөхөн төлүүлэх талаар гарсан шүүхийн шийдвэрийн биелэлтийг төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллагаас гаргуулан авах;

2.1.3.төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, тэдгээртэй адилтгах албан тушаалын зэрэг дэв олгох саналаа эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

2.1.4.шаардлагатай асуудлаар судалгаа, шинжилгээг мэргэшсэн байгууллагаар хийлгэх, шинжээчдийг татан оролцуулах;

2.1.5.Төрийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэгт заасан тэмдэглэлийн үндэслэлийг шалгаж тогтоох;



2.1.6.Төрийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6, 32.7 дахь хэсэгт заасан үндэслэлээр холбогдох албан тушаалтныг огцруулах, үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг хууль тогтоомжийн дагуу зохих эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2.1.7.Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэгт заасан асуудлаар төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах;

2.1.8.ажлын албаны дотоод зохион байгуулалт, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжийн бүтэц, орон тоог тогтоох;

2.1.9.Олон нийтийн хяналтын зөвлөлийг сонгон шалгаруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, зөвлөлийн ажиллах дүрмийг батлах;

2.1.10.салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжийн удирдлагыг томилох, чөлөөлөх;

2.1.11.төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг боловсруулан батлахад Улсын Их Хурал, Засгийн газарт санал өгөх;

2.1.12.гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын байгууллагатай харилцаа, хамтын ажиллагаа тогтоох.

### **Гурав.Зөвлөлийн чиг үүрэг, үйл ажиллагааны хамрах хүрээ**

3.1.Зөвлөл доор дурдсан чиг үүргийг хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ дагуу дараах хүрээнд хэрэгжүүлнэ:

3.1.1.Төрийн жинхэнэ албаны ерөнхий болон тусгай шалгалтыг зохион байгуулах хүрээнд:

3.1.1.а.төрийн жинхэнэ албаны ерөнхий болон тусгай шалгалтыг зохион байгуулах, арга зүйн зөвлөгөө өгөх;

3.1.1.б.төрийн албаны мэргэшлийн шалгалтын сорил, бодлогын даалгавар, ярилцлагын асуулт, хариултын санг бүрдүүлж, шалгалтын агуулга, хэлбэрийг албан тушаалын тодорхойлолтод заагдсан тусгай шаардлага, ур чадварт нийцүүлэн тогтмол шинэчлэх;



3.1.1.в.төрийн албаны мэргэшлийн шалгалтын агуулгыг боловсруулах, шалгалтыг зохион байгуулахад холбогдох байгууллага, албан хаагч, мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах.

3.1.2.Хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээ хийх хүрээнд:

3.1.2.а.төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх;

3.1.2.б.төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудитыг Зөвлөлөөс баталсан төлөвлөгөө, зааврын дагуу хийж, хүний нөөцийн удирдлагын чиг үүргийг сайжруулах зөвлөмж гаргах;

3.1.2.в.төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх;

3.1.2.г.төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих;

3.1.2.д.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг бий болгосон бодлогын хэрэгжилт, төрийн албан дахь ялгаварлан гадуурхалтын талаарх гомдлыг барагдуулах үйл ажиллагаанд хяналт тавих.

3.1.3.Маргаан хянан шийдвэрлэх хүрээнд:

3.1.3.а.Төрийн албаны тухай хуулийн 75 дугаар зүйлд заасан маргааныг хянан шийдвэрлэх;

3.1.3.б.маргаан хянан шийдвэрлэсэн Зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хангуулах;

3.1.3.в.төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах.

3.1.4.Сургалт судалгаа зохион байгуулах, мэдээллийн нэгдсэн санг эрхлэх хүрээнд:

3.1.4.а.төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, төрийн алба, албан хаагчтай холбоотой мэдээллээр хангах;





3.1.4.б.төрийн жинхэнэ албан тушаалтныг мэргэшүүлэх багц сургалт, албан тушаалын ажлын байран дахь сургалтын агуулга, хөтөлбөрийн талаар санал боловсруулах;

3.1.4.в.төрийн албатай холбогдсон судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах.

3.1.5.Мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх хүрээнд:

3.1.5.а.Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.9-д заасан асуудлаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн удирдах ажилтныг мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээгээр хангах;

3.1.5.б.төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийхэд мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх;

3.1.5.в.ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах;

3.1.5.г.төрийн албаны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэхэд зөвлөгөө өгөх.

3.2.Зөвлөл хууль тогтоомжид заасны дагуу зарим чиг үүргээ Засгийн газрын бус байгууллагад гэрээний үндсэн дээр хариуцуулан гүйцэтгүүлж болно.

### **Дөрөв.Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, арга хэлбэр**

4.1.Зөвлөл үйл ажиллагаагаа дөрвөн жилийн стратеги төлөвлөгөө, түүнд нийцүүлсэн жил бүрийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

4.2.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хуралдаан байна.

4.3.Зөвлөлийн хуралдааныг Зөвлөлийн дарга, эсхүл гишүүдийн олонхын саналаар зарлан хуралдуулах бөгөөд Зөвлөлийн гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцно.

4.4.Зөвлөлийн хуралдаанаар Зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

4.5.Зөвлөл хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргана. Бүрэн эрхийнхээ хүрээнд албан даалгавар, зөвлөмж гаргаж болно. Зөвлөлөөс гаргасан шийдвэрт Зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

4.6.Хуралдааны дэгийг Зөвлөл тогтооно.

4.7.Зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг Зөвлөл баталж, мөрдүүлнэ.

4.8.Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтыг Зөвлөлийн баталсан хуваарийн дагуу жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулах бөгөөд тусгай шалгалтыг шаардлага гарсан тухай бүрд, Зөвлөлийн шийдвэрлэсэн хугацаанд зохион байгуулна.

4.9.Зөвлөл хүний нөөцийн аудитыг төлөвлөн тогтмол зохион байгуулна.

4.10.Зөвлөлөөс зохион байгуулах хяналт шалгалтын ажлыг холбогдох байгууллагуудын хяналт шалгалттай уялдуулан зохион байгуулна.

4.11.Зөвлөлөөс зохион байгуулах судалгаа, шинжилгээний ажлын сэдэв, чиглэлийг хуралдаанаараа хэлэлцэн батална. Судалгааг гэрээний үндсэн дээр зохих мэргэжлийн байгууллага, судлаач, эрдэмтдээр гүйцэтгүүлж болно.

4.12.“Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнах журмыг баталж, төрийн албан хаагчийг шагнаж урамшуулах бусад хэлбэрийг тогтоон мөрдүүлнэ.

4.13.Зөвлөлийн ажлын гүйцэтгэл, үр дүнг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.14.Зөвлөл үйл ажиллагааныхаа тайланг дараа оны нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлнэ. Тайланд Төрийн албаны тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан мэдээллийг бүрэн тусгана.

4.15.Зөвлөл гадаад харилцаагаа гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын хүрээнд зохион байгуулна.



### **Тав.Зөвлөлийн зохион байгуулалтын бүтэц**

5.1.Зөвлөл өөрийн бүтцийн нэгж болох Ажлын алба /цаашид “Ажлын алба” гэх/, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл /цаашид “Салбар зөвлөл” гэх/, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжтэй байна.

5.2.Ажлын алба, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжийн үйл ажиллагааны дүрмийг Зөвлөл батална.

5.3.Зөвлөл Ажлын албаны даргыг Зөвлөлийн даргын саналыг үндэслэн томилж, чөлөөлнө.

5.4.Ажлын албаны дарга нь Зөвлөлийн төсвийн шууд захирагч байх бөгөөд Ажлын албаны дотоод журмыг тогтооно.

5.5.Ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.5.1.Зөвлөл бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийн дагуу мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгч, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх;

5.5.2.Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэх;

5.5.3.Зөвлөлийн ажиллах хэвийн нөхцөлийг хангах.

5.6.Зөвлөл Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг тус тус томилж, чөлөөлнө.

5.7.Аймаг, нийслэлд Салбар зөвлөл ажиллана. Төрийн захиргааны төв байгууллага, агентлагт Салбар зөвлөл ажиллуулах асуудлыг тухайн салбар, байгууллагын төрийн албан хаагчдын тоо, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны хамрах хүрээг харгалзан Зөвлөл шийдвэрлэнэ.

5.8.Салбар зөвлөл төрийн албаны тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан дүрэм, журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, Зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

5.9.Салбар зөвлөл нь үйл ажиллагаагаа хараат бусаар явуулна.

5.10.Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь Салбар зөвлөлийг үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангаж, шаардлагатай зардлыг төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

5.11.Зөвлөл Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээ, ажиллах журмыг тогтоон мөрдүүлнэ.

5.12.Төрийн албаны хүний нөөцийн асуудлаар Салбар зөвлөлийн харьяалах байгууллагыг Зөвлөл тогтооно. Салбар зөвлөлгүй төрийн байгууллагын хүний нөөцийн асуудлыг Зөвлөл хариуцна.

5.13.Зөвлөл Салбар зөвлөлд мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгч, удирдана.

5.14.Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг Зөвлөлийн төсөвт тусгана. Нэгжийн зарим үйлчилгээ төлбөртэй байж болно.

5.15.Зөвлөлийн дэргэдэх сургалт судалгаа, мэдээллийн сангийн нэгж нь төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн нэгдсэн санг бүрдүүлж, хуульд заасны дагуу үйлчилгээ үзүүлэх, Зөвлөлөөс тогтоосон хүрээнд сургалт судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.16.Ажлын алба, Салбар зөвлөл, сургалт судалгаа, мэдээллийн сангийн нэгж нь тогтоосон журмаар үйлдсэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

### **Зургаа.Зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрх**

6.1.Зөвлөлийн дарга Төрийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхээс гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.1.Зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд Төрийн албаны тухай хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;

6.1.2.Зөвлөлийн Ажлын алба, Салбар зөвлөл, Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжийн үйл ажиллагааг удирдлагаар хангах;

6.1.3.Зөвлөлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх;

6.1.4.Зөвлөлийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

6.1.5.Бүрэн эрхийн хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргах;



6.1.6.Зөвлөлийн ажлын хэсэг, комиссын бүрэлдэхүүнийг томилох;

6.1.7.Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын шинжтэй асуудлаар журам батлах;

6.1.8.Зөвлөлийн хараат бус, бие даасан байдлыг хангах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд шаардлага тавих, санал оруулж шийдвэрлүүлэх;

6.1.9.Ажлын албаны дарга, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжийн удирдлагыг томилуулах саналыг Зөвлөлийн хуралдаанд оруулах;

6.1.10.Зөвлөлийг бусад байгууллагад төлөөлөхдөө Зөвлөлийн албан ёсны шийдвэр, байр суурийг илэрхийлэх;

6.1.11.албан үүргээ Зөвлөлийн аль нэг гишүүнээр түр орлон гүйцэтгүүлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл бүрэн эрхийнхээ зарим хэсгийг хэрэгжүүлэх талаар хязгаарлалт тавьж болно.

6.2.Зөвлөлийн гишүүн дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

6.2.1.Ажил үүргийн хуваарийн дагуу Зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

6.2.2.Зөвлөлөөс томилсон ажлын хэсэг, комиссыг ахлан ажиллах;

6.2.3.Зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар санал боловсруулж, Зөвлөлийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

6.2.4.Зөвлөлийн хуралдааныг хуралдуулах санал гаргах, шаардах;

6.2.5.Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан нэмэлт материал, мэдээллийг Ажлын албанаас шаардах, танилцах, хэлэлцэж байгаа асуудлаар зарчмын зөрүүтэй байр сууриа илэрхийлэх, хуралдааны тэмдэглэлд тусгуулах;

6.2.6.Зөвлөлийн даргын түр эзгүйд түүний үүрэг болгосноор Зөвлөлийн даргыг орлон ажиллах;

6.2.7.Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт, томилгоотой холбоотой шийдвэр гаргах, маргаан хянан шийдвэрлэхдээ шударга, ашиг сонирхлоос ангид, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй байх.



## **Долоо.Зөвлөл бусад байгууллага, иргэдтэй харилцах**

7.1.Зөвлөл хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусад байгууллага, иргэдтэй дараах байдлаар харилцана:

7.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон холбогдох бусад асуудлаар өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлж, биелэлтийг нь тогтоосон хугацаанд мэдээлэх;

7.1.2.төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн нэгдсэн сангаас төрийн бүх шатны байгууллагыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хууль тогтоомжид заасны дагуу хангах;

7.1.3.Төрийн албаны тухай хуульд заасан асуудлаар Зөвлөлийн саналыг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлэх;

7.1.4.төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газар, Үндэсний аудитын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Авлигатай тэмцэх газар болон холбогдох бусад байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулж, харилцан мэдээлэл солилцох;

7.1.5.яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, төрийн захиргааны бусад байгууллагатай Ажлын алба, Салбар зөвлөлөөрөө уламжлах буюу шууд харилцаж, хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулан авах, төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөмж, чиглэл өгөх, мэргэшил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх зэргээр харилцан ажиллаж, хууль тогтоомжийг сурталчлах, сургалт, зөвлөгөөн зохион байгуулах хэлбэрээр хамтран ажиллах;

7.1.6.төрийн байгууллагуудтай харилцан ажиллахдаа Зөвлөл нь тэдгээрийн чиг үүргийг орлон гүйцэтгэхгүй байх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцохгүй байх зарчмыг баримтлах.

7.2.Зөвлөл төрийн албаны чадахуйн зарчимд үндэслэсэн шатлан дэвшүүлэх үйл ажиллагаанд улс төрийн албан тушаалтан, улс төрийн нам, эвслийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, бусад этгээдийн зүгээс төрийн албан тушаалд томилох үйл явцад саад учруулсан, хөндлөнгөөс оролцсон, аливаа хэлбэрээр нөлөөлсөн асуудлыг шалган нягтлахад шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримт материалыг төрийн аль ч шатны байгууллага, албан тушаалтнаас болон улс төрийн нам, эвслийн удирдах,



гүйцэтгэх ажилтнаас шаардан гаргуулна. Ийнхүү Зөвлөлийн шаардсан мэдээ, мэдээлэл, баримт материалыг төрийн байгууллага, албан тушаалтан, бусад этгээд тогтоосон хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй.

7.3.Зөвлөл өөрийн үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд ил тод мэдээлнэ.

7.4.Зөвлөл Төрийн албаны тухай хуулийн 56 дугаар зүйлд заасан Олон нийтийн хяналтын зөвлөлтэй мэдээлэл солилцож, түүний мэдээлэл, зөвлөмжийн дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 18

Улаанбаатар  
хот

### Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай

Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэл”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 06 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**



Монгол Улсын Их Хурлын 2019 оны  
18 дугаар тогтоолын хавсралт

**УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАСГИЙН ГАЗАР, УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ,  
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДСЭНИЙ КОМИСС, ТӨРИЙН АЛБАНЫ  
ЗӨВЛӨЛ, ҮНДСЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ, СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО, САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО, ҮНДСЭНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО, ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН  
АЛБАНЫ УДИРДАХ, ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ**

Ангилал	Албан тушаалын ангилал зэрэглэл		Улсын Их Хурлын Тамгын газар	Ерөнхийлөгчийн Тамгын газар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Улсын дээд Шүүхийн Тамгын газар	Үндсэн хуулийн цэцийн ажлын алба	Улсын ерөнхий прокурорын газар	Хүний эрхийн Үндэсний комиссын ажлын алба	Төрийн албаны зөвлөлийн ажлын алба	Үндэсний аюулгүй зөвлөлийн ажлын алба	Үндэсний аюулгүй байдалын зөвлөлийн ажлын алба	Сонгуулийн ерөнхий хорооны ажлын алба	Санхүүгийн хорооны ажлын алба	Үндэсний статистикийн хороо	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	
	Зэрэглэл	Ангилал															
Тэргүүн Түшмэл	AA-1	Нарийн бичгийн дарга	Дэд дарга	Дэд дарга	Тамгын газрын дарга	Тамгын газрын дарга	Тамгын газрын дарга	Тамгын газрын дарга	Ажлын албаны дарга	Ажлын албаны дарга	Ажлын албаны дарга	Ажлын албаны дарга	Ажлын албаны дарга	Ажлын албаны дарга	Тамгын газрын дарга	-	-
	AA-2	Хэлтэс, албаны дарга	Хэлтэс, албаны дарга	Гаарын дарга	Тамгын газрын дарга	Тамгын газрын дарга	Тамгын газрын дарга	Тамгын газрын дарга	Ажлын албаны дарга	Ажлын албаны дарга	Ажлын албаны дарга	Ажлын албаны дарга	Ажлын албаны дарга	Ажлын албаны дарга	Ажлын албаны дарга	Тамгын газрын дарга	-





	AA-3	-	-	Хэлтсийн дарга	Хэлтсийн дарга	Хэлтсийн дарга	Хэлтсийн дарга	Гаазрын дарга	Хэлтсийн дарга	Хэлтсийн дарга	Хэлтсийн дарга	Хэлтсийн дарга	Гаазрын дарга	Гаазрын дарга	Гаазрын дарга
	AA-4	Тасгийн дарга, ахлах зөвлөх	Тасгийн дарга, ахлах зөвлөх	Албаны дарга, ахлах зөвлөх	Хэлтсийн дарга, ахлах зөвлөх	Алба, Г/өвч-ийн дарга	Тасгийн дарга	Хэлтэс, Тасгийн дарга	Хэлтэс, Тасгийн дарга	Хэлтэс, Албаны дарга, Ахлах зөвлөх	Тасгийн дарга	Хэлтэс, Албаны дарга	Хэлтэс, Албаны дарга	Хэлтэс, Албаны дарга	Хэлтэс, Албаны дарга
Эрхэлсэн түшмэл	AA-5	Зөвлөх, ахлах референт	Зөвлөх, ахлах референт	Зөвлөх, ахлах референт	Зөвлөх, ахлах референт	Тасгийн дарга, ахлах референт	Зөвлөх, ахлах референт	Зөвлөх, ахлах референт	Ахлах референт	Зөвлөх, ахлах референт	Ахлах референт	Ахлах референт, Ахлах референт	Ахлах референт, Ахлах референт	Ахлах референт, Ахлах референт	Ахлах референт
Ахлах түшмэл	AA-6	Референт	Референт	Референт	Референт	Референт	Референт	Референт	Референт	Референт	Референт	Референт	Референт	Референт	Референт
	AA-7	Ахлах шинжээч	Ахлах шинжээч	Ахлах шинжээч	Ахлах шинжээч	Ахлах шинжээч	Ахлах шинжээч	Ахлах шинжээч	Ахлах шинжээч	Ахлах шинжээч	Ахлах шинжээч	Ахлах шинжээч	Ахлах шинжээч	Ахлах шинжээч	Ахлах шинжээч
	AA-8	Шинжээч	Шинжээч	Шинжээч	Шинжээч	Шинжээч	Шинжээч	Шинжээч	Шинжээч	Шинжээч	Шинжээч	Шинжээч	Шинжээч	Шинжээч	Шинжээч
Дэс түшмэл	AA-9	Ахлах мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн
	AA-10	Мэргэжилтэн	Мэргэжилтэн	Мэргэжилтэн	Мэргэжилтэн	Мэргэжилтэн	Мэргэжилтэн	Мэргэжилтэн	Мэргэжилтэн	Мэргэжилтэн	Мэргэжилтэн	Мэргэжилтэн	Мэргэжилтэн	Мэргэжилтэн	Мэргэжилтэн
	AA-11	Ахлах зохион байгуулагч	Ахлах зохион байгуулагч	Ахлах зохион байгуулагч	Ахлах зохион байгуулагч	Ахлах зохион байгуулагч	Ахлах зохион байгуулагч	Ахлах зохион байгуулагч	Ахлах зохион байгуулагч	Ахлах зохион байгуулагч	Ахлах зохион байгуулагч	Ахлах зохион байгуулагч	Ахлах зохион байгуулагч	Ахлах зохион байгуулагч	Ахлах зохион байгуулагч

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 19

Улаанбаатар  
хот

### **Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай**

Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.“Төрийн өндөр албаны тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2002 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 73 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**



**ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГ ЗИНДАА, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ  
ТӨРИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГЛЭЛ**

Зэрэг зиндаа	Улс төрийн албан тушаал	Захиргааны албан тушаал	Тусгай албан тушаал	Адилтгах албан тушаалын зэрэглэл	Улс төрийн албан тушаал	Захиргааны албан тушаал	Тусгай албан тушаал
<b>ТӨ-I</b>	Монгол Улсын Ерөнхийлөгч						
<b>ТӨ-II</b>	Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд						
<b>ТӨ-III</b>	Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Шадар сайд		Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч				
<b>ТӨ-IV</b>	Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд		Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Монгол Улсын Ерөнхий прокурор	<b>ТӨ-IVA</b>	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	Монгол банкны Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий аудитор, Авлигатай тэмцэх газрын дарга

<p><b>ТӨ-V</b></p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</p>	<p>Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга</p>	<p>Монгол Улсын дээд шүүхийн шүүгч</p>	<p><b>ТӨ-VA</b></p>	<p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Аймгийн Засаг дарга</p>	<p>Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дарга Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн</p>	<p>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монгол Үндэсний статистикийн хорооны дарга, Улсын Ерөнхий прокурорын орлогч, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Авлигатай тэмцэх газрын дэд дарга</p>
<p><b>ТӨ-VI</b></p>	<p>Дэд сайд</p>	<p>Засгийн газрын Хэрэг-эрхлэх газрын тэргүүн дэд дарга</p>		<p><b>ТӨ-VIA</b></p>	<p>Ерөнхийлөгчийн зөвлөх, Улсын Их Хурлын даргын зөвлөх, Ерөнхий сайдын зөвлөх</p>	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн</p>	<p>Монгол банкны тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Үндэсний статистикийн хорооны дэд дарга, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга</p>



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 02 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 20

Улаанбаатар  
хот

### **Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам батлах тухай**

Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 75 дугаар зүйлийн 75.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2003 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

Монгол Улсын Их Хурлын 2019 оны  
20 дугаар тогтоолын хавсралт

### **ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧ БОЛОН ТӨРИЙН АЛБАНД НЭР ДЭВШИГЧИЙН ЭРХ ЗӨРЧИГДСӨН ТУХАЙ МАРГААНЫГ ХҮЛЭЭН АВЧ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ**

#### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1 дүгээр зүйл.Журмын зорилго**

1.1.Энэ журмын зорилго нь Төрийн албаны зөвлөл /Цаашид “Зөвлөл” гэх/ төрийн албанд томилох эрх бүхий этгээд болон төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэгт заасан асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

## **2 дугаар зүйл.Маргаан хянан шийдвэрлэхэд баримтлах хууль тогтоомж**

2.1.Энэ журмын 1.1-д заасан маргааныг хянан шийдвэрлэхдээ Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Захиргааны ерөнхий хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журмыг баримтална.

2.2.Зөвлөл маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг зөвхөн гомдлоор үүсгэн явуулна.

## **3 дугаар зүйл.Нэр томьёоны тодорхойлолт**

3.1.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“гомдол” гэж энэ журмын 5 дугаар зүйлд заасан асуудлаар төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчээс өөрийн хууль ёсны эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг;

3.1.2.“маргаан” гэж Төрийн албаны тухай хууль болон энэ журамд заасны дагуу төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албаны хүний нөөцийн удирдлага, шийдвэр, үйл ажиллагаа болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгаатай холбогдсон асуудлаар үүссэн саналын зөрүүг;

3.1.3.“төрийн албаны хүний нөөцийн удирдлагатай холбогдон гаргасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр” гэж төрийн жинхэнэ албанд нэр дэвшигч болон төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалд сонгон шалгаруулж нэр дэвшүүлэх, шатлан дэвшүүлэх, томилох, чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, дэвшүүлэх, үр дүнгийн гэрээ байгуулах, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, зэрэг дэв олгох, сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зэрэг хүний нөөцийн удирдлагын хүрээнд гаргасан захиргааны актыг.

## **4 дүгээр зүйл.Маргаан хянан шийдвэрлэх зарчим**

4.1.Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

- 4.1.1.хууль дээдлэх;
- 4.1.2.ил тод байх;
- 4.1.3.шударга ёсыг баримтлах;



- 4.1.4.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 4.1.5.шуурхай, тасралтгүй байх;
- 4.1.6.талуудын тэгш эрхийг хангах.

## **5 дугаар зүйл.Маргааны харьяалал**

5.1.Зөвлөл нь төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай дараах маргааныг хянан шийдвэрлэнэ:

5.1.1.Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалд томилохтой холбогдсон маргаан;

5.1.2.Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн захиргааны албан тушаалд томилох үндсэн шалгууртай холбогдсон маргаан;

5.1.3.Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалд сонгон шалгаруулж томилохтой холбогдсон маргаан;

5.1.4.Төрийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг захиргааны санаачилгаар албан тушаал бууруулсантай холбогдсон маргаан;

5.1.5.Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь түр чөлөөлсөн, чөлөөлсөнтэй холбогдсон маргаан;

5.1.6.Төрийн албаны тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь халсантай холбогдсон маргаан;

5.1.7.Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулсантай холбогдсон маргаан;

5.1.8.Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэгт заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, цол, зэрэг дэв олгох, урамшуулах, зохих шатны сургалтад хамруулах, албан тушаал бууруулах, хариуцлага хүлээлгэх асуудалтай холбогдсон маргаан;

5.1.9.Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.11-д заасны дагуу төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт /тухайн албан тушаалын/-ыг зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулахтай холбогдсон маргаан;

5.1.10.Төрийн албаны тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэгт заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчаас цалин хөлс, ажиллах нөхцөл, баталгааны талаар гаргасан бусад маргаан.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ГОМДОЛ ГАРГАХ, МАРГААН ҮҮСГЭХ**

### **6 дугаар зүйл.Зөвлөлд гомдол гаргах**

6.1.Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигч эрх зөрчигдсөн тухай гомдлоо бичгээр гаргах бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:

6.1.1.өөрийн овог нэр, эрхэлж байгаа албан тушаал, оршин суугаа газрын болон шуудангийн хаяг, гарын үсэг;

6.1.2.маргаан үүсгэх хуулийн үндэслэл, холбогдох нотолгоо, баримт бичгийн хуулбар;

6.1.3.маргаан бүхий захиргааны акт, шийдвэрийг гаргасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны нэр хаяг, үйл ажиллагааны талаар.

6.2.Маргаанд холбогдох асуудлаар 2 ба түүнээс дээш этгээд хамтран бичгээр гомдол гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурна.

6.3.Хэрэв гомдол гаргагч бусдаар төлөөлүүлэх бол энэ тухай итгэмжлэлийг хавсаргана.

6.4.Энэ журмын 6.1-д заасан этгээд маргаан бүхий захиргааны акт болон шийдвэрийг хуульд заасны дагуу хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн албаны зөвлөл болон түүний Салбар зөвлөлд гомдол гаргана.

6.5.Төрийн албаны зөвлөл болон Салбар зөвлөл энэ журмын 6.1-д заасан шаардлагыг хангаагүй, мөн 6.4-д заасан хугацаа хэтэрсэн бол гомдлыг хүлээж авахгүй.





## **7 дугаар зүйл.Маргаан үүсгэх**

7.1.Зөвлөл гомдлыг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор маргаан үүсгэх эсэх талаар шийдвэр гаргана.

7.2.Маргаан үүсгэсэн бол Зөвлөлийн дарга гомдолд дурдсан маргааны шинж байдлыг харгалзан маргаан хянан шалгах комисс /цаашид “комисс” гэх/-ыг 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

7.3.Комиссын бүрэлдэхүүнд Зөвлөлийн гишүүн, ажлын албаны ажилтан, тухайн салбар зөвлөлийн гишүүн, түүнчлэн төрийн захиргааны бусад байгууллагаас төрийн албаны ажлын туршлагатай, мэргэшсэн албан хаагчийг оролцуулж болно.

7.4.Зөвлөлийн аль нэг гишүүн комиссыг даргалж, маргааныг хянан шалгах ажлыг хариуцан зохион байгуулна.

7.5.Комисс нь маргааныг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд хугацааг Зөвлөлийн дарга 14 хоногоор сунгаж болно.

7.6.Энэ журамд заасан маргаанд хамаарахгүй болон харьяаллын биш гомдлыг харьяалах байгууллагад шилжүүлэх буюу гомдол гаргагчид буцааж хариу өгнө.

## **8 дугаар зүйл.Маргааныг бүртгэх**

8.1.Зөвлөл маргаан үүсгэсэн гомдлын талаар тусгай бүртгэл хөтөлж, дугаар олгоно.

8.2.Комиссын нарийн бичгийн дарга тухайн маргааныг бүртгүүлж, дугаар авна.

## **9 дүгээр зүйл.Хориглох зүйл**

9.1.Комиссын бүрэлдэхүүнд гомдол гаргасан этгээдтэй эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн болон хамаарал бүхий ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг оруулахыг хориглоно.

9.2.Комиссын гишүүн нь ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал илэрсэн бол комиссын гишүүнээс татгалзан гарна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ МАРГААН ХЯНАН ШАЛГАХ

### 10 дугаар зүйл.Маргаан хянан шалгах

10.1.Комисс нь маргааныг хянан шалгахдаа дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

10.1.1.маргагч талууд болон бусад холбогдох этгээдээс тайлбар авах;

10.1.2.холбогдох байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр зохих мэргэжлийн хүмүүсийг хянан шалгах ажиллагаанд татан оролцуулах;

10.1.3.хянан шалгах ажиллагаанд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

10.1.4.хянан шалгах ажиллагааны явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулах;

10.1.5.гомдол, маргаанд холбогдох асуудлын хүрээнд маргагч талуудаас болон холбогдох бусад этгээдээс тайлбар гаргуулах, нотлох баримтын бүрдлийг хангуулахаар Салбар зөвлөлд үүрэг, чиглэл өгч биелэлтийг хангуулах;

10.1.6.илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

10.1.7.хянан шалгах ажиллагаа, дүгнэлт, танилцуулга, албан шаардлага, баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах;

10.1.8.маргагч талууд харилцан ойлголцож гомдол гаргасан тал нь гомдлоосоо сайн дураараа татгалзвал маргаан хянан шалгах ажиллагааг дуусгавар болгож, тэмдэглэл үйлдэх;

10.1.9.Зөвлөлийн хуралдаанд маргаан хянан шийдвэрлэсэн комиссын танилцуулга, дүгнэлт болон тогтоолын төслийг танилцуулах;



10.1.10.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

**11 дүгээр зүйл.Комиссын үйл ажиллагааны зохион байгуулалт**

11.1.Комиссын хуралдааныг комиссын дарга удирдан явуулна.

11.2.Хуралдаанаар шийдвэрлэсэн асуудалд зарчмын шинжтэй өөрчлөлт оруулах бол заавал хуралдаанаар дахин хэлэлцүүлж шийдвэрлэнэ.

11.3.Комиссын нарийн бичгийн дарга хуралдаанаар хэлэлцүүлэх баримт бичгийн төслийн эцсийн хувилбарыг боловсруулах, бэлтгэх, олшруулах, тараах зэрэг ажлыг хариуцан гүйцэтгэх ба хуралдааны тэмдэглэл хөтөлнө.

**12 дугаар зүйл.Комиссын дүгнэлт**

12.1.Комисс маргааныг хянан шалгасан дүнг хуралдаанаараа хэлэлцэж, комиссын гишүүдийн олонхын саналаар дүгнэлт гаргана.

12.2.Комиссын дүгнэлт нь удиртгал, тэмдэглэх, дүгнэх хэсгээс бүрдэнэ.

12.3.Удиртгал хэсэгт дүгнэлтийн дугаар, гаргасан он, сар, өдөр, комиссын дарга болон бусад гишүүд, нарийн бичгийн дарга, гомдол гаргагчийн овог нэр, эрхэлж байгаа албан тушаал, маргаан үүсгэсэн үндэслэлийг заана.

12.4.Тэмдэглэх хэсэгт маргаан хянан шалгах явцад цугларсан нотлох баримтад дүн шинжилгээ хийж, үнэлж дүгнэсэн байдлыг тодорхойлно. Ямар нотлох баримтыг хүлээн зөвшөөрсөн, ямар нотлох баримтаас татгалзсан зэргийг дэлгэрэнгүй тайлбарлаж, дүгнэлтийн үндэслэлийг заана.

12.5.Дүгнэх хэсэгт маргаан хянан шийдвэрлэхэд баримталсан хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалт болон маргаан бүхий асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн, ямар дүгнэлт гаргаж байгааг тусгана.

12.6.Дүгнэлтэд комиссын гишүүд гарын үсэг зурж албажуулна.

12.7.Комиссын гишүүн дүгнэлтэд санал нэгдээгүй, эсхүл эсрэг саналтай бол энэ тухай үндэслэлээ бичгээр гаргаж өгнө. Комиссын гишүүний бичгээр гаргасан саналыг дүгнэлтэд заавал хавсаргана.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ**

### **13 дугаар зүйл.Зөвлөлийн хуралдаанаар маргаан хянан хэлэлцэх**

13.1.Зөвлөлийн хуралдаанд комиссын хуралдаанаас гарсан дүгнэлтийг комиссын дарга танилцуулна.

13.2.Зөвлөлийн хуралдаанаар комиссын дүгнэлтийг хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэнэ.

13.3.Зөвлөлийн гишүүд болон комиссоос санал болгосон тохиолдолд маргагч талуудыг хуралдаанд оролцуулж, тэдэнд дүгнэлтийн талаар тайлбар хийх бололцоог олгоно.

13.4.Зөвлөл нь дараах үндэслэлээр гомдлыг дахин шалгуулахаар комисст буцаах шийдвэр гаргаж болно.

13.4.1.шийдвэр гаргахад шаардагдах нотолгоо болон баримт бичгийн бүрдэл хангагдаагүй;

13.4.2.маргаанд холбогдох баримт бичиг, бусад материалыг шалгаагүй буюу хангалтгүй шалгасан;

13.4.3.маргааныг хянан шалгасан дүнг комисс хуралдаанаараа хэлэлцээгүй;

13.4.4.комиссын гишүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилтэйгээр оролцсон нь тогтоогдсон.

13.5.Зөвлөл шаардлагатай гэж үзвэл маргаан хянан шалгах комиссыг шинээр байгуулж, маргаан шийдвэрлэх хугацааг тогтооно.

13.6.Зөвлөлийн дарга, гишүүд маргаан хянан шийдвэрлэхэд адил тэгш эрхтэй оролцох бөгөөд маргааны асуудлаар өөрийн санал, байр сууриа илэрхийлж, тайлбарлах эрхтэй.

### **14 дүгээр зүйл.Зөвлөлийн шийдвэр гаргах**

14.1.Зөвлөл комиссын дүгнэлтийг хэлэлцээд, тогтоол гаргана.

14.2.Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол Зөвлөл тухайн шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгоно.



14.3.Зөвлөл гаргасан шийдвэрээ ажлын гурван өдөрт багтаан албажуулж, маргагч талуудад хүргүүлнэ.

14.4.Зөвлөлийн гаргасан шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

14.5.Холбогдох байгууллага, албан тушаалтан Зөвлөлийн шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 14 өдрийн дотор уг шийдвэрийн биелэлтийн талаар хариу ирүүлнэ.

14.6.Энэ журмын 14.4-т заасныг зөрчсөн этгээдэд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРТ ГОМДОЛ ГАРГАХ**

#### **15 дугаар зүйл.Шүүхэд гомдол гаргах**

15.1.Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн тал уг шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

15.2.Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн гомдлоор хэрэг үүсгэсэн тохиолдолд Зөвлөлийн даргын тушаалаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулна.

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 02 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 21

Улаанбаатар  
хот

### **Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай**

Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Төрийн захиргааны албан хаагчид 2019 онд олгох зэрэг дэвийн нэмэгдлийг баталсан төсвийн хэмжээнд багтаан зохицуулж,

цаашид шаардагдах зардлыг 2020 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1995 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 73 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

Монгол Улсын Их Хурлын 2019 оны  
21 дүгээр тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН  
ЗЭРЭГ ДЭВ, ТҮҮНИЙ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэв олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

**Хоёр.Зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох**

2.1.Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу төрийн захиргааны албан тушаал нь доор дурдсан зэрэг дэвтэй байх бөгөөд төрийн захиргааны албан хаагчид дараах байдлаар олгоно:

Түшмэлийн албан тушаалын ангилал	Албан тушаалын зэрэг дэв	Хамаарах төрийн захиргааны албан тушаал
Тэргүүн түшмэл	-Тэргүүн зэрэг -Дэд зэрэг -Гутгаар зэрэг -Дөтгөөр зэрэг	Яамны Төрийн нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлаас албан тушаалын ангилал зэрэглэл нь тогтоогддог байгууллагын Ажлын албаны дарга болон газрын дарга, Засгийн газрын агентлагийн дарга, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал;



Эрхэлсэн түшмэл	-Тэргүүн зэрэг -Дэд зэрэг -Гутгаар зэрэг -Дөтгөөр зэрэг	Яамны газар, хэлтсийн дарга, Засгийн газрын Агентлагийн дэд дарга, түүний газрын дарга, Улсын Их Хурлаас албан тушаалын ангилал зэрэглэл нь тогтоогддог байгууллагын Ажлын албаны хэлтэс, тасгийн дарга, ахлах референт, Аймаг, нийслэлийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга, аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, тэдгээртэй адилтгах бусад удирдах албан тушаал;
Ахлах түшмэл	-Тэргүүн зэрэг -Дэд зэрэг -Гутгаар зэрэг -Дөтгөөр зэрэг	Яамны тасгийн дарга, ахлах шинжээч, шинжээч, Засгийн газрын Агентлагийн хэлтсийн дарга, Улсын Их Хурлаас албан тушаалын ангилал зэрэглэл нь тогтоогддог байгууллагын Ажлын албаны референт, ахлах шинжээч, шинжээч, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын нэгжийн дарга, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал;
Дэс түшмэл	-Тэргүүн зэрэг -Дэд зэрэг -Гутгаар зэрэг -Дөтгөөр зэрэг	Яамны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, ахлах зохион байгуулагч, Засгийн газрын агентлагийн гүйцэтгэх ахлах албан тушаал, Улсын Их Хурлаас албан тушаалын ангилал зэрэглэл нь тогтоогддог байгууллагын Ажлын албаны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, ахлах зохион байгуулагч, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэх албан тушаал, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал;
Туслах түшмэл	-Тэргүүн зэрэг -Дэд зэрэг -Гутгаар зэрэг -Дөтгөөр зэрэг	Яамны зохион байгуулагч, Засгийн газрын агентлагийн гүйцэтгэх албан тушаал, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал.

2.2.Тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Ерөнхийлөгч, эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг яам, төрийн бусад байгууллагын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Ерөнхий сайд тус тус шинээр болон ахиулан олгоно. Өргөн мэдүүлэхдээ Төрийн албаны төв байгууллагын саналыг авсан байна.

2.3.Төрийн захиргааны ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох асуудлыг Монгол Улсын сайд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Үндсэн

хуулийн цэцийн дарга, Улсын ерөнхий прокурор, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Төрийн албаны зөвлөлийн дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний статистикийн хорооны дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын Агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус шийдвэрлэнэ.

2.4.Төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох саналыг уг албан хаагчийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана.

2.5.Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т заасан төрийн албанд ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин болон мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 23.2.2, 23.2.3-т заасан тусгай шаардлагыг хангасан төрийн захиргааны албан хаагчид доорх байдлаар албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгоно:

Түшмэлийн албан тушаалын ангилал	Албан тушаалын зэрэг дэв	Ажилласан хугацаа /жилээр/		
		Төрийн албанд	Өмнөх ангилалд	Тухайн ангиллын албан тушаалд
Тэргүүн түшмэл	Тэргүүн зэрэг	16-аас доошгүй жил	Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 8-аас доошгүй жил	4 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			3 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			2 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш
Эрхэлсэн түшмэл	Тэргүүн зэрэг	12-оос доошгүй жил	Ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил	4 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			3 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			2 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш
Ахлах түшмэл	Тэргүүн зэрэг	8-аас доошгүй жил	Дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил	4 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			3 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			2 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш





Дэс түшмэл	Тэргүүн зэрэг	4-өөс доошгүй жил	Туслах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил	4 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			3 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			2 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш
Туслах түшмэл	Тэргүүн зэрэг	3-аас доошгүй жил	Ажилласан хугацаа шаардахгүй	4 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			3 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			2 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш

2.6.Төрийн захиргааны албан тушаалд томилогдож нэг жил ажилласан төрийн захиргааны албан хаагчид төрийн албанд ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үндэслэн тухайн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалын дөтгөөр зэргийг олгож, улмаар зэрэг дэвийг ахиулах зарчим баримтална. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг алгасаж олгохгүй.

2.7.Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т заасны дагуу хугацаанаас өмнө шатлан дэвшиж томилогдсон төрийн захиргааны албан хаагчид тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг олгохдоо Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т заасан төрийн албанд ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин болон мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 23.2.2, 23.2.3-т заасан тусгай шаардлагыг хангасан төрийн захиргааны албан хаагчид доор дурдсанаар албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгоно:

Түшмэлийн албан тушаалын ангилал	Албан тушаалын зэрэг дэв	Ажилласан хугацаа /жилээр/		
		Төрийн албанд	Өмнөх ангилалд	Тухайн ангиллын албан тушаалд
Тэргүүн түшмэл	Тэргүүн зэрэг	8-аас доошгүй жил	Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 4-аас доошгүй жил	4 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			3 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			2 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш



Эрхэлсэн түшмэл	Тэргүүн зэрэг	6-аас доошгүй жил	Ахлах түшмэлийн албан тушаалд 2-аас доошгүй жил	4 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			3 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			2 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш
Ахлах түшмэл	Тэргүүн зэрэг	4-өөс доошгүй жил	Дэс түшмэлийн албан тушаалд 2-өөс доошгүй жил	4 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			3 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			2 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш

2.8.Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2-т заасны дагуу төрийн захиргааны албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тохиолдолд тухайн албан хаагчийн албан тушаалын зэрэг дэвийг бууруулахгүй.

2.9.Төрийн захиргааны албан хаагчаас өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаал буурсан тохиолдолд тухайн төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын зэрэг дэвийг бууруулахгүй.

2.10.Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл хөлсийг тухайн албан хаагчийн албан тушаалын цалингаас доор дурдсан хувиар тооцож, сар тутам олгоно:

Албан тушаалын ангилал	Зэрэг дэвийн нэмэгдэл /хувиар/			
	Тэргүүн зэрэг	Дэд зэрэг	Гутгаар зэрэг	Дөтгөөр зэрэг
Тэргүүн түшмэл	48	46	44	42
Эрхэлсэн түшмэл	40	38	36	34
Ахлах түшмэл	32	30	28	26
Дэс түшмэл	24	22	20	18
Туслах түшмэл	16	14	12	10

### Гурав.Зэрэг дэвийг хэвээр хадгалах, олгохгүй байх

3.1.Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасан төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэлтэй байгаа иргэн, мөн хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4-т заасны дагуу төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар



албан тушаалын орон тоо нь хасагдаж төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн иргэн төрийн жинхэнэ албан тушаалд хууль тогтоомжийн хүрээнд томилогдвол түүний зэрэг дэвийг хэвээр хадгална.

3.2.Төрийн захиргааны албан хаагчид дараах тохиолдолд албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгохгүй:

3.2.1.зэрэг дэв олгох хугацааны шалгуурыг хангасан боловч төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь хангалтгүй үнэлэгдсэн;

3.2.2.хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй.

### **Дөрөв.Албан тушаалын зэрэг дэвийг хэрэглэх**

4.1.Төрийн захиргааны албан тушаал эрхэлж байгаа албан хаагч албан тушаалын зэрэг дэвийг дараах байдлаар хэрэглэж болно:

4.1.1.албан бичиг, захидал харилцаанд;

4.1.2.албан ажлын өрөөний хаяг, нэрийн хуудсанд;

4.1.3.хурал, цуглаан, уулзалт, хүлээн авалтын танилцуулгад.

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 02 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл;

2/“Монгол Улсын 2018 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан;

3/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт;

4/“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

5/“Засгийн газрын өрийн удирдлагын стратеги шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

6/Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл;

7/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл;

8/Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл;

9/Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл;

10/Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл;

11/Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

12/Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл;

13/Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

14/Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

15/Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

16/Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

17/Эх оронч худалдан авалтын тухай хуулийн төсөл;

18/Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;



19/Өмгөөллийн тухай хуулийн төсөл;  
20/Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

21/Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төсөл;  
22/Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

23/Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

24/Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

25/Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслүүд;

26/Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

27/Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

28/Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн төсөл;

29/Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

30/бусад.

2.Хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн энэ тогтоолын 1-д зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3.Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчаас өргөн мэдүүлбэл хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Монгол Улсын Их Хурлын дарга /Г.Занданшатар/-д зөвшөөрсүгэй.

4.Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Ц.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2018 оны 10 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 327

Улаанбаатар  
хот

### **Журам батлах тухай**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. “Гамшгийн зэрэглэл тогтоох журам”-ыг 1 дүгээр, “Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт”-ийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшинд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**

**Ө.ЭНХТҮВШИН**

Засгийн газрын 2018 оны 327 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

## **ГАМШГИЙН ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аюулт үзэгдэл, ослын улмаас үүссэн гамшгийг тодорхойлох, гамшгийн зэрэглэлийг тогтооход энэ журмыг мөрдлөг болгоно.

1.2. Гамшгийн нөхцөл байдлыг үнэлэх, гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга



хэмжээг удирдлага зохицуулалтаар хангах, хүмүүнлэгийн тусламж хүсэх, үүссэн нөхцөл байдлын талаар нийтэд мэдээлэхэд гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, гамшгийн зэрэглэлийг үндэслэл болгоно.

#### Хоёр. Гамшгийг тодорхойлох

2.1. Тохиолдсон аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, хамарч байгаа хүрээ, хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учруулсан хор уршгийг илэрхийлсэн шалгуур үзүүлэлтээр гамшгийг тодорхойлно.

2.2. Аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлыг аюулын эрчимжилт, хор хөнөөлийн түвшин, үргэлжлэх хугацаагаар үнэлэх бөгөөд аюулын эрчимжилт, хор хөнөөлийн түвшинг түүний хурд, хүч, нягтрал, хөнөөлийн зэргээр, үргэлжлэх хугацааг цаг, өдөр, сараар тус тус тооцно.

2.3. Гамшгийн хор уршгийн нөхцөл байдлыг тодорхойлохдоо нэрвэгдсэн, амь насаа алдсан хүний тоо, хорогдсон болон өвчилсэн мал, амьтан, хамарсан хүрээ, нийгэм, эдийн засагт учруулсан бодит хохирлоор үнэлэх бөгөөд мал, амьтны өвчлөл, хорогдлыг нийт мал, амьтны тоо толгойд эзлэх хувиар, хамрах хүрээг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээ, барилга, байгууламжийн ач холбогдлоор, нийгэм, эдийн засагт учруулсан бодит хохирлыг тухайн орон нутгийн төсөвт эзлэх хувиар тус тус тооцно.

2.4. Тухайн гамшгийн төрөлд хамаарах нийт шалгуур үзүүлэлтийн 50 хувь нь бүрдсэн байвал гамшиг болсонд тооцно.

2.5. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлтэд ашиглах мэдээ, мэдээллийг байгаль орчин, хөдөө аж ахуй, санхүү, эдийн засаг, эрүүл мэнд, дэд бүтцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд болон ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, шаардлагатай гэж үзсэн бусад мэргэжлийн байгууллагатай хамтран тухай бүр шинэчилж байна.

#### Гурав. Гамшгийн зэрэглэл

3.1. Гамшигт нэрвэгдсэн, амь насаа алдсан хүний тоо, хамарсан нутаг дэвсгэрийн хэмжээ, гамшгийн хор уршгийг арилгах ажиллагааны удирдлага зохицуулалт, оролцсон хүч хэрэгслийг харгалзан гамшгийг орон нутгийн, бүсийн, улсын хэмжээний гэж зэрэглэл тогтоож, шар, улбар шар, улаан өнгөөр тэмдэглэнэ.



Гамшгийн зэрэглэл	Гамшгийн түвшин	Нэрвэгдсэн хүний тоо	Амь насаа алдсан хүний тоо	Хамарсан нутаг дэвсгэр	Удирдлага	Оролцох хүч хэрэгсэл
Орон нутгийн	Шар	10 хүртэл	2 хүртэл	2 хүртэл аймаг, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан	Тухайн орон нутгийн онцгой комисс, Онцгой байдлын газар, хэлтэс	Аймаг, дүүрэг, сумын гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл
Бүсийн	Улбар шар	11-99 хүртэл	3-9 хүртэл	Тухайн бүсийн 3 ба түүнээс дээш аймаг, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан	Улсын онцгой комисс, ОБЕГ	Бүс, нийслэл болон аймаг, дүүргийн гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл
Улсын хэмжээний	Улаан	100 ба түүнээс дээш	10 ба түүнээс дээш	2 ба түүнээс дээш бүс, нийслэлийг хамарсан	Засгийн газар, Улсын онцгой комисс, ОБЕГ	Улсын гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл, Зэвсэгт хүчний анги, салбар

3.2. Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг ашиглан гаргасан мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн шатны онцгой комисс гамшгийн зэрэглэлийг тогтооно.

3.3. Аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас үрэгдэх, улсын онц чухал объект, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд ноцтой эвдрэл гэмтэл гарч, нийгэм, эдийн засаг, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, гамшгийн зэрэглэлээс үл хамаарч гамшгийн нөхцөл байдал үүссэнд тооцож, Засгийн газар, Улсын онцгой комисс удирдлага зохицуулалтаар хангана.

Дөрөв. Бусад

4.1. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



Засгийн газрын 2018 оны 327 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

ГАМШГИЙГ ТОДОРХОЙЛОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

		Шалгуур үзүүлэлт							
		Аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал				Хор уршгийн нөхцөл байдал			
Гамшгийн төрөл	Аюултын эрчимжилт, хор хөнөөлийн түвшин	Үргэлжлэх хугацаа	Нэрвэгдсэн хүний тоо	Нас барсан хүний тоо	Нийт мал, амьтны хоргодол (тус бүр хувиар)	Нийт мал, амьтны хоргодол (тус бүр хувиар)	Нийт амьтны хоргодол (тус бүр хувиар)	Хамрах хүрээ	Учирсан бодит хохирлын орон нутгийн төсөвт эзлэх хувь
1	2	3	4	5	6	7	8	9	
Ой, хээрийн гал түймэр	Түймрийн тархах хурд 1 хүртэл км/цаг	Ойн түймэр 15-20 хоног, хээрийн түймэр 3-5 хоног	10-20	2 ба түүнээс дээш	2.0	-	Ойн талбай 200 га-аас дээш, хээрийн талбай 1000 га-аас дээш, ойролцоо 5 км-ийн бүсэд дэд бүтцийн байгууламж орших, газар тариалан эрхэлж байгаа аж ахуйн нэгж (ААН), иргэний ашиглаж байгаа талбайн 30-аас дээш хувийг хамарсан	2.0	



Хүчтэй, хүй салхи	Дундаж хурд 18м/с, түүнээс их (өрөвхийлэлт 24 м/с түүнээс их)	Хугацаа хамаарахгүй	10 болон түүнээс дээш	2 ба түүнээс дээш	-	-	Нутаг дэвсгэрийн гуравны нэгээс дээш хувийг хамарсан, Дэд бүтцийн байгууламж, улсын онц чухал объектод гэмтэл учрах	2.0
Цасан болон шороон шуурга	Салхины дундаж хурд 10 м/с болон түүнээс их, алсын бараа 2000 м-ээс бага болох	3 цаг, түүнээс дээш	10 болон түүнээс дээш	2 ба түүнээс дээш	-	-	Нутаг дэвсгэрийн гуравны нэгээс дээш хувийг хамарсан, Дэд бүтцийн байгууламж, улсын онц чухал объектод гэмтэл учрах	2.0
Аянга	Дулааны бургилалтын үүл босоо чиглэлд хөгжин хөгжлийн дээд шатандаа хүрч, тодорхой нөхцөлд цахилгаан цэнэг хуримтлагдаж үүл газрын хооронд ниргэлт явагдах үзэгдэл	Хугацаа хамаарахгүй	10 болон түүнээс дээш	2 ба түүнээс дээш	-	-	-	2.0
Үер	-Гол, мөрний ус үерийн түвшинд хүрэх, -Хүчтэй аадар борооны ус луу жалга, хэвгий даган шавар, шороо, чулуутай хопилдож хуйтран урсах	Хугацаа хамаарахгүй	10 болон түүнээс дээш	2 ба түүнээс дээш	-	-	10-15 айл өрх, 3-5 хүртэл ААН, 1-3 хүртэл дэд бүтцийн байгууламж	2.0



	Ган	<p>Жилийн 5-8 дугаар сард агаарын хамгийн их температур өндөр уулын бүсэд +25°C, ойт хээр, хээрийн бүсэд +30°C, говь цөлийн бүсэд +32°C болон түүнээс их, агаарын харьцангуй чийг 30 хувиас бага буюу хуурайшилттай хоногийн тоо 10 хоногт 5, сард 15-аас олон байх</p>	1 сар ба түүнээс дээш	50 болон түүнээс дээш	-	1 хувь ба түүнээс дээш	-	Нутаг дэвсгэрийн гуравны нэгээс дээш хувийг хамарсан, газар тариалан эрхэлж байгаа ААН, иргэний ашиглаж байгаа талбайн 30-аас дээш хувийг хамарсан	2.0
Зуд		<p>10 хоног болон сарын дундаж агаарын температур олон жилийн дунджаас 3°C болон түүнээс хүйтэн, бэлчээрийн цасны нягт 0.25 г/см<sup>3</sup> ба түүнээс их, цасны дундаж зузаан уулын болон ойт хээрийн бүсэд 25 см-ээс, хээрийн бүсэд 22 см-ээс, говь цөлийн бүсэд 12 см-ээс их байх, мал тэжээл, усаар дутагдах, эсвэл цасны өнгөн хэсэг ба гүндээ мөсөн бүрхэвч тогтсоноос мал бэлчээрлэх боломжгүй болох</p>	14 хоног ба түүнээс дээш	50 болон түүнээс дээш	-	2 хувь ба түүнээс дээш	-	Нутаг дэвсгэрийн гуравны нэгээс дээш хувийг хамарсан	2.0

Газар хөдлөлт	4 ба түүнээс дээш магнитудын хүчтэй	Хугацаа хамаарахгүй	10 ба түүнээс дээш	2 ба түүнээс дээш	-	-	Боловсрол, эрүүл мэндийн болон бусад суурь үйлчилгээ тасалдах, Дэд бүтцийн байгууламж, улсын онц чухал объектод гэмтэл учрах	2.0
Малын гоц халдварт өвчин	Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалтад орсон өвчин гарсан	Хугацаа хамаарахгүй	50 болон түүнээс дээш	-	Зориудын устгал нь 10 хувь ба түүнээс дээш		2 ба түүнээс дээш аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан	2.0
Хүний гоц халдварт өвчин	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан "Шинэ ба сэргэн тархаж буй халдварт өвчний ангилал"-ын А, В, С жагсаалтад байгаа болон Олон улсын Эрүүл мэндийн дүрмийн Хавсралт 2 хүснэгтийн дагуу шийдвэр гаргах схемээр зохицуулагдан мэдээлэгддэг хүний халдварт өвчнүүд	Хугацаа хамаарахгүй	50 болон түүнээс дээш	2 ба түүнээс дээш	-	-	Нутаг дэвсгэрийн гуравны нэгээс дээш хувийг хамарсан	2.0
Хортон шавьж мэрэгчдийн тархалт	1 га талбайд 100-аас дээш тоотой хортон мэрэгч тархсан 1 м <sup>2</sup> талбайд 17-оос дээш тоотой хортон шавьж тархсан	Хугацаа хамаарахгүй	-	-	-	-	Нутаг дэвсгэрийн гуравны нэгээс дээш хувийг хамарсан	2.0

Объектын гал түймэр	Гал түймэр хүний амь нас, эрүүл мэндэд хөнөөл учруулах хэмжээнд хүрэх, бусад барилга, байгууламжид тархан дэлгэрэх	Хугацаа хамаарахгүй	10 болон түүнээс дээш	2 ба түүнээс дээш	-	-	Нийтийн барилга, байгууламж, Улсын онц чухал объект, Гал түймрийн эрсдэлийн 1, 2, 3 дугаар зэргийн барилга байгууламж	2.0
Химийн хорт бодис алдагдах	Химийн хорт болон аюултай бодис хүрээлэн байгаа орчин дахь тухайн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэх	Хугацаа хамаарахгүй	10 болон түүнээс дээш	2 ба түүнээс дээш	-	-	Хордуулах аюул ариутгал, хамгаалалтын бүсээс гадагш тархаж тухайн нутаг дэвсгэрийн гуравны нэгээс дээш хувийг хамарсан	2.0
Цацрагийн осол	Олон улсын атомын энергийн агентлагаас гаргасан Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага NoGSR Part-7 "Цөмийн болон цацрагийн ослын бэлэн байдал, хариу арга хэмжээ" баримт бичигт заасан нөхцөл байдал үүсч цацраг идэвхт бодис алдагдах	Хугацаа хамаарахгүй	10 болон түүнээс дээш	2 ба түүнээс дээш	-	-	Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрмийн дагуу ослын шарлагын бүх замуудыг тооцож, эдгээрт хүн амын ослын үед авах эффeктив тунгийн түвшин 100 мЗв -ээс их хэмжээтэй цацраг идэвхт бодисоор бохирдох	2.0

Тэсрэлт, дэлбэрэлт	50 кПа ба түүнээс дээш хүчтэй энерги ялгарах	Хугацаа хамаарахгүй	10 болон түүнээс дээш	2 ба түүнээс дээш	-	Боловсрол, эрүүл мэндийн болон бусад суурь үйлчилгээ үзүүлдэг байгууллагын барилга байгууламж, Дэд бүтцийн байгууламж, улсын онц чухал объектод гэмтэл учрах	2.0
Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс үүсэх осол	Үйлдвэрлэл, технологийн горим, барилгын норм, норматив зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах	Хугацаа хамаарахгүй	10 болон түүнээс дээш	2 ба түүнээс дээш	-	Нийгмийн суурь үйлчилгээ тасалдах, тоног төхөөрөмж, барилга байгууламж эвдрэх нурах, Дэд бүтцийн байгууламж, улсын онц чухал объектод гэмтэл учрах	2.0
Тээврийн хэрэгслийн осол, сүйрэл	Усан болон хуурай зам, агаарын тээврийн хэрэгсэл осолдож сүйрэх	Хугацаа хамаарахгүй	50 болон түүнээс дээш	2 ба түүнээс дээш	-	-	2.0



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 332

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам батлах тухай**

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19.5-д заасныг үндэслэн  
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2002 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 214 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Ц.НЯМДОРЖ**

Засгийн газрын 2018 оны 332 дугаар  
тогтоолын хавсралт

### **МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ИРГЭН ШИЛЖИН СУУРЬШИХ ХӨДӨЛГӨӨНИЙГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэний шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Сум, хорооны улсын бүртгэгч иргэний байнга оршин суугаа газрын хаягийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь хаягийн бүртгэлээр тодорхойлно.

1.3. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь хаягийн санг газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягуулалтын нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн үүсгэнэ.

1.4. Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагч, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх иргэнийг түр оршин суугчаар бүртгэнэ.

1.5. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журмыг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.

1.6. Энэхүү журмын биелэлтэд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь газар, хэлтэс хяналт тавина.

Хоёр. Иргэний байнга оршин суух шилжилт  
хөдөлгөөнийг бүртгэх

2.1. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй хаягаас өөр хаягт шилжин 180 хоногоос дээш хугацаагаар оршин суух иргэн Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19.1-д заасны дагуу дараахь баримт бичгийг бүрдүүлж, оршин суух сум, хорооныхоо улсын бүртгэгчид 10 хоногийн дотор өөрийн биеэр бүртгүүлнэ:

2.1.1. иргэний үнэмлэх;

2.1.2. арван зургаан нас хүрээгүй хүүхэдтэй бол хүүхдийн төрсний гэрчилгээ;

2.1.3. оршин суух газрын хаягаа нотлох баримт бичиг;

2.1.4. Цэргийн албаны тухай хуулийн 34.6.4-т заасны дагуу шилжин очсон газраа цэргийн бүртгэлд бүртгүүлсэн тэмдэглэгээ хийлгэсэн цэргийн үүрэгтний үнэмлэх.

2.2. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19.1.3-т заасан “оршин суух газрын хаягаа нотлох баримт бичиг” гэдэгт дараахь баримт бичиг хамаарна:

2.2.1. эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

2.2.2. газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ;

2.2.3. нотариатаар гэрчлүүлсэн түрээсийн, захиалгын зэрэг гэрээ;





2.2.4. үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эсхүл эзэмшигчийн бичгээр гаргасан оршин суулгах тухай зөвшөөрөл.

2.3. Энэхүү журмын 2.1-д зааснаар иргэн өөрийн биеэр бүртгүүлэх боломжгүй тохиолдолд Иргэний хуулийн 62.3-т заасны дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан бүртгүүлж болно.

2.4. Сум, хорооны улсын бүртгэгч нь иргэний шилжилт хөдөлгөөнийг бүртгэхдээ Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19.1-д заасан баримт бичгийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь мэдээлэлтэй тулган шалгана.

2.5. Сум, хорооны улсын бүртгэгч дараахь үндэслэлээр иргэний шилжилт хөдөлгөөнийг бүртгэхгүй:

2.5.1. энэ журмын 2.1-д заасан баримт бичиг дутуу бол;

2.5.2. энэ журмын 2.1-д заасан баримт бичиг зөрчилтэй бол.

2.6. Сум, хорооны улсын бүртгэгч иргэний шилжилт хөдөлгөөнийг бүртгэлийн дэвтэрт бүртгэж, холбогдох мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулна.

2.7. Арван зургаан нас хүрээгүй хүүхдийн оршин суугаа газрын хаягийн бүртгэлийг түүний эцэг (эх), асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн байнга оршин суугаа газрын хаягаар бүртгэнэ.

2.8. Сум, хорооны улсын бүртгэгч иргэний шилжилт хөдөлгөөнийг мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулахдаа тухайн иргэний иргэний үнэмлэхийн санах ойд хаягийн мэдээллийг оруулна.

2.9. Сум, хорооны улсын бүртгэгч иргэний шилжилт хөдөлгөөнийг бүртгэлийг энэхүү журмын 2.1-д заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор Иргэний улсын бүртгэл хөтлөх журамд заасны дагуу хөтөлнө.

Гурав. Иргэний түр оршин суух шилжилт  
хөдөлгөөнийг бүртгэх

3.1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28.1.11 дэх заалт, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 27.1-д заасны дагуу Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй хаягаас өөр хаягт шилжин 180 хоног ба түүнээс доош хугацаагаар түр оршин суух иргэний шилжилт хөдөлгөөнийг баг, хорооны Засаг дарга бүртгэнэ.

3.2. Баг, хорооны Засаг дарга иргэний түр оршин суух шилжилт хөдөлгөөнийг бүртгэхэд энэхүү журмын 2.1.1-2.1.3, 2.2, 2.3, 2.5, 2.7-д заасныг баримтална.

Дөрөв. Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг  
түдгэлзүүлэх, түр зогсоох

4.1. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19.4-т заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгийн болон газар өмчлөх эрх нь дуусгавар болсон боловч Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь хаягийн бүртгэлд өөрчлөлт ороогүй тохиолдолд холбогдох иргэний хүсэлтийг үндэслэн гаргасан хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийг түдгэлзүүлж болно.

4.2. Сонгуулийн тухай хуулийн 63.2, 66.1-д заасны дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг дараахь тохиолдолд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр түр зогсооно:

4.2.1. Монгол Улсын Их Хурлын, Монгол Улсын Ерөнхийлөгчийн, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрөөс 60 хоногийн өмнө;

4.2.2. Монгол Улсын Их Хурлын, Монгол Улсын Ерөнхийлөгчийн, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус, дахин, нөхөн сонгууль явуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэрийг улсын бүртгэлийн байгууллагад ирүүлсэн өдрөөс эхлэн санал авах өдрийг дуустал хугацаанд тухайн сонгуулийн тойрог, хэсгийн засаг захиргааны нэгжийн хэмжээнд.

Тав. Шилжилт хөдөлгөөнийг мэдээлэх

5.1. Баг, хорооны Засаг дарга түр оршин суух иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн тоон мэдээ, мэдээллийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын баталсан маягтын дагуу цаасан болон цахим хэлбэрээр улирал бүрийн сүүлийн сарын 30-ны өдрөөр тасалбар болгон дараа сарын 10-ны өдрийн дотор аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлнэ.

5.2. Энэхүү журмын 5.1-д заасны дагуу ирүүлсэн тоон мэдээ, мэдээллийг аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нэгтгэн, тухайн сарын 25-ны өдрийн дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын иргэний улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 11 дүгээр  
сарын 14-ний өдөр

Дугаар 339

Улаанбаатар  
хот

### Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам батлах тухай

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Ц.НЯМДОРЖ**

Засгийн газрын 2018 оны 339 дүгээр  
тогтоолын хавсралт

### ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭР БАТАЛГААЖУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Иргэн, хуулийн этгээдээс хуулийн этгээдийн нэр авах хүсэлт гаргах, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтад тавигдах шаардлага, хязгаарлалтыг тогтоох, хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулахад энэ журмыг баримтална.

1.2. Иргэн, хуулийн этгээд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13.1-д заасны дагуу дараахь тохиолдолд хуулийн этгээдийн нэр авах хүсэлт гаргаж, тухайн нэрийн баталгаажуулалт хийлгэнэ:

- 1.2.1. хуулийн этгээдийг шинээр байгуулах;
- 1.2.2. хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах;
- 1.2.3. хуулийн этгээдийн нэрийг өөрчлөх.

1.3. Хуулийн этгээдийн нэр баталгаажуулахад улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын баталсан хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын маягтыг ашиглана.

1.4. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газарт нэр олгохгүй бөгөөд тухайн хуулийн этгээдийн нэрээр нэрлэнэ.

Хоёр. Хуулийн этгээдийн нэр авах хүсэлт гаргах

2.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13.1-д заасны дагуу дараахь этгээд хуулийн этгээдийн нэр авах, баталгаажуулах хүсэлтийг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр улсын бүртгэлийн байгууллагад гаргана:

- 2.1.1. хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч;
- 2.1.2. хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага;
- 2.1.3. итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд.

2.2. Энэ журмын 2.1-д заасан этгээд хуулийн этгээдийн нэр авах хүсэлтийг биечлэн, эсхүл цахим хэлбэрээр гаргаж болно.

2.3. Энэ журмын 2.1-д заасан этгээд хуулийн этгээдийн нэр авах хүсэлтийг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд улсын бүртгэлийн байгууллагын цахим хуудаст байршуулсан хуулийн этгээдийн оноосон нэр захиалах системийг ашиглаж эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаяг зэрэг мэдээллийг оруулан бүртгүүлж, нэрийн хайлт хийж, сонгосон нэрээ авах хүсэлтээ илгээнэ.

2.4. Татан буугдсан, нэрээ өөрчилсөн хуулийн этгээдийн нэрийг авах хүсэлтийг тухайн хуулийн этгээдийн татан буугдсаныг, эсхүл нэр өөрчилснийг улсын бүртгэлд бүртгэснээс хойш 30 хоногийн дараа гаргаж болно.

Гурав. Хуулийн этгээдийн нэрэнд тавигдах  
шаардлага, хязгаарлалт

3.1. Улсын бүртгэлийн байгууллага Иргэний хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмаар тогтоосон шаардлага, хязгаарлалтыг хангасан нэрийг баталгаажуулна.



3.2. Хуулийн этгээдийн нэр тухайн хуулийн этгээдийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг тусгасан байна.

3.3. Хуульд заасан тохиолдолд хуулийн этгээдийн нэр тухайн хуулийн этгээдийн төрлийг заасан байна.

3.4. Хуулийн этгээдийн нэр монгол хэлээр, кирилл үсгээр илэрхийлэгдсэн байна.

3.5. Олон улсад түгээмэл хэрэглэгддэг, шинжлэх ухааны, салбарын, хуулийн болон мэргэжлийн үг, хэллэг бүхий нэр энэ журмын 3.4-т хамаарахгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд нэр томъёоны талаар Монгол хэлний тухай хуулийн 22.2.7-д зааснаар Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Монгол хэл шинжлэлийн хүрээлэнд хүсэлт гарган шийдвэрлүүлж болно.

3.6. Хуулийн этгээдийн нэр нь улсын нэр хүнд, язгуур эрх ашиг, үндэсний өв соёл, зан заншилд харшлах утга илэрхийлээгүй байна.

3.7. Хуулийн этгээдийн нэрэнд тоо орсон тохиолдолд уг тоог кирилл үсгээр бичнэ. Жишээлбэл: “Нийслэлийн ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль” гэх мэт.

3.8. Хуульд заасан тохиолдолд хуулийн этгээдийн нэрийн хойно үйл ажиллагааны чиглэлийг илэрхийлсэн үг, эсхүл товчилсон үгийг хэрэглэнэ. Жишээлбэл: “Өмгөөллийн мэргэн ХХН”, “Алтан төгрөг ББСБ” гэх мэт.

3.9. Боловсрол, соёл, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн нэр холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн байна. Жишээлбэл: “Нийслэлийн ерөнхий боловсролын тавдугаар сургууль”, “Алтан чагнуур өрхийн эрүүл мэндийн төв” гэх мэт.

3.10. Хуулийн этгээдийн нэр Иргэний хуулийн 27.3-т зааснаар өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй бөгөөд дараахь тохиолдолд бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй гэж үзэж баталгаажуулахгүй:



3.10.1. хуулийн этгээдийн нэрийн санд бүртгэгдсэн хуулийн этгээдийн нэрийн өмнө болон хойно зохион байгуулалтын хэлбэрийг тусгасан бол. Жишээлбэл: хуулийн этгээдийн нэрийн санд “Төмөр” гэсэн нэр бүртгэгдсэн байвал “Төмөр групп”, “Төмөр концерциум”, “Төмөр холдинг”, “Төмөр корпораци” гэсэн нэрийг;

3.10.2. төрийн өмчит хуулийн этгээдээс бусад хуулийн этгээдийн нэрийн өмнө болон хойно Монгол, МН, Эм Жи Эл, МЖЛ, Мон, МНЖ зэргээр “Монгол” гэсэн утга санаагаар ялгаж бичсэн бол. Жишээлбэл: хуулийн этгээдийн нэрийн санд “Төмөр” гэсэн нэр бүртгэгдсэн байвал “Төмөр МН”, “Төмөр Монгол”, “Мон төмөр” гэсэн нэрийг;

3.10.3. хуулийн этгээдийн нэрийн санд бүртгэгдсэн нэрийн хойно тоо бичсэн бол. Жишээлбэл: хуулийн этгээдийн нэрийн санд “Номин” гэсэн нэр бүртгэгдсэн бол “Номин нэг”, “Номин хоёр” гэсэн нэрийг;

3.10.4. баталгаажуулах нэр нь бичвэр, хэлбэр, авианы дуудлагын хувьд хуулийн этгээдийн нэрийн санд бүртгэгдсэн нэрийн үгийн үндэс, үеэр төсөөтэй бол. Жишээлбэл: хуулийн этгээдийн нэрийн санд “Баян гео”, “Эко систем” гэсэн нэр бүртгэгдсэн байвал “Баян геологи”, “Экологи систем” гэсэн нэрийг;

3.10.5. холбоо, сангийн нэрийг Монголын, Монгол Улсын, үндэсний, нэгдсэн, нийтийн, салбарын, мэргэжлийн гэсэн үгээр ялгаж бичсэн бол. Жишээлбэл: хуулийн этгээдийн нэрийн санд “Монголын скаутын холбоо” гэсэн нэр бүртгэгдсэн байвал “Монголын Үндэсний скаутын холбоо”, “Монгол Улсын скаутын холбоо” гэсэн нэрийг;

3.10.6. холбоо, сангийн нэрэнд Монголын, Монгол Улсын, үндэсний, нэгдсэн, нийтийн, салбарын, мэргэжлийн, олон улсын, Азийн, Европын зэрэг нийтийг төлөөлсөн утга бүхий үг оруулан төөрөгдүүлэхээр бичсэн бол. Жишээлбэл: “Монголын залуу гоо сайханчдын нэгдсэн холбоо”, “Олон улсын гар бөмбөгийн спорт сонирхогчдын холбоо” гэх мэт нэрийг;

3.10.7. холбоо, сангийн нэрийн хойно нийгэмлэг, академи, холбоо, зөвлөл, дээд зөвлөл, нэгдэл, төв, хүрээлэн, институт, танхим, клуб зэрэг үгээр ялгаж бичсэн бол. Жишээлбэл: хуулийн этгээдийн нэрийн санд “Малчдын холбоо” гэсэн нэр бүртгэгдсэн байвал “Малчдын зөвлөл”, “Малчдын клуб” гэсэн нэрийг;



3.10.8. төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс бусад хуулийн этгээдийн нэрийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэрээр ялган бичсэн бол. Жишээлбэл: хуулийн этгээдийн нэрийн санд “Дорнын саран” гэсэн нэр бүртгэгдсэн байвал “Завхан дорнын саран” гэсэн нэрийг;

3.10.9. төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс бусад хуулийн этгээдийн нэрэнд төрийн байгууллагын чиг үүрэг, нэрийг оролцуулан бичсэн бол. Жишээлбэл: “Дагнасан оюуны өмчийн газар” ТББ, “Мэргэшсэн оюуны өмчийн газар” ХХК гэсэн нэрийг;

3.10.10. хуулийн этгээдийн нэрэнд хуулийн дагуу сонгогддог болон томилогддог албан тушаалын нэрийг оролцуулан бичсэн бол. Жишээлбэл: “Ард түмний ерөнхийлөгч”, “Улсын Их Хурлын шилдэг гишүүн” гэсэн нэрийг;

3.10.11. хуулийн этгээдийн нэрэнд дараахь үгийг хуулиар хориглосон, эсхүл нийтийн ёс суртахууны хэм хэмжээнд сөргөөр нөлөөлөх, эмх замбараагүй байдал үүсгэх, өдөөн турхирах байдлаар бичсэн бол. Тухайлбал, тэмцэгчид, тэмцэл, босогч, дайтагч, дайчилгаа, терроризм, галт зэвсэг, хар тамхи, мансууруулах бодис, олон шатлалт маркетинг, пирамид, мөрийтэй болон бооцоот тоглоом, казино, садар самуун явдал болон архи, тамхи, тамхины үйлдвэр гэх мэт;

3.10.12. чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэхээс бусад хуулийн этгээдийн нэрэнд “... чөлөөт бүс” гэж бичсэн бол.

3.11. Энэ журмын 3.10.1 дэх заалт өмнө нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдэд хамаарахгүй.

#### Дөрөв. Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах

4.1. Энэ журмын 2.1-д заасан этгээд хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулахад дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

4.1.1. иргэний үнэмлэх, эсхүл үндэсний гадаад паспортын хуулбар;



4.1.2. эрх бүхий этгээдийн шийдвэр;

4.1.3. итгэмжлэлээр эрх олгогдсон этгээдийн тухайд итгэмжлэл;

4.1.4. үйлчилгээний хөлс төлсөн баримт.

4.2. Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах хүсэлт гаргасан этгээдийг биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-өөр таньж болох бөгөөд энэ тохиолдолд энэ журмын 4.1.1-д заасан баримт бичгийг шаардахгүй.

4.3. Улсын бүртгэгч энэ журмын 2.1-д заасан этгээдийн хүсэлтийн дагуу тухайн сонгосон нэрийг хуулийн этгээдийн нэрийн санд шалгаж, холбогдох хууль тогтоомж, энэ журамд нийцсэн тохиолдолд баталгаажуулна.

4.4. Улсын бүртгэгч хуулийн этгээдийн нэр баталгаажуулахад энэ журмын 1.3-т заасан хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын маягтыг хуулийн этгээдийн нэрийн сангаас хэвлэн гарын үсэг, хувийн дугаар бүхий тэмдгээр баталгаажуулж хүсэлт гаргасан этгээдэд олгоно.

4.5. Энэ журмын 4.3, 4.4-т заасны дагуу баталгаажсан хуулийн этгээдийн нэр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу 30 хоногийн дотор хүчинтэй байна.

4.6. Энэ журмын 2.1-д заасан этгээд энэ журмын 4.5-д заасан хугацаа дуусахаас өмнө хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хугацааг сунгах хүсэлт гаргасан тохиолдолд уг хугацааг 60 хүртэл хоногоор сунгаж болно.

4.7. Энэ журмын 4.5, 4.6-д заасан хугацаанд хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдлийг улсын бүртгэлийн байгууллагад гаргаагүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хүчингүй болох бөгөөд энэ тохиолдолд хуулийн этгээдийн нэр баталгаажуулах хүсэлтийг энэ журамд заасны дагуу дахин гаргаж болно.

4.8. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу санхүүгийн тайлангаа найм болон түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж





баталгаажуулаагүй үндэслэлээр хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассанаас хойш нэг жилийн хугацаанд тухайн хуулийн этгээдийн нэрийг мөн хуулийн 26.3-т заасны дагуу олгохгүй.

Тав.Бусад

5.1. Хуулийн этгээдийн нэртэй холбоотой маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 3,5

**Индекс: 200003**